



LOS ANGELES ТОЙРОГ БҮРТГЭГЧ-ТЭМДЭГЛЭГЧ/ТОЙРГИЙН АЖИЛТАН

2022 ОНЫ АРВАННЭГДҮГЭЭР САРЫН ЕРӨНХИЙ СОНГУУЛИЙН ТУХАЙ Б.А.А

СОНГОГЧИЙН БҮРТГЭЛ

САНАЛ ӨГӨХӨӨР ХЭРХЭН БҮРТГҮҮЛЭХ ВЭ?

- ▲ Санал өгөхөөр бүртгүүлэх хамгийн хялбар арга бол онлайнаар **LAVOTE.GOV** хаягаар орж бүртгүүлэх юм.
- ▲ Сонгогчийн бүртгэлийн өргөдлийг номын сан, DMV оффис, Norwalk дахь Бүртгэлийн төв оффис зэрэг төрийн ихэнх байранд авах боломжтой.
- ▲ Сонгогчид энэ удаагийн сонгуулиар Шуудангаар Өгөх Саналын Хуудас авахын тулд **Арваннэгдүгээр сарын 24-ний** дотор бүртгүүлэх ёстой.

БИ БҮРТГЭЛИЙН БАЙДЛАА ХЭРХЭН ШАЛГАХ ВЭ?

- ▲ Сонгогчид **LAVOTE.GOV/VRSTATUS** цахим хуудаснаас өөрийн бүртгэлийн байдал, мэдээллээ шалгах боломжтой.

БИ БҮРТГЭЛИЙН ХУГАЦААНД БҮРТГҮҮЛЭЭГҮЙ БОЛ САНАЛ ӨГӨХ БОЛОМЖТОЙ УУ?

- ▲ Тийм. Эрх бүхий хүн бүр **Аравдугаар сарын 24-ны өдөр** сонгуулийн бүртгэлээс хоцорсон бол Лос Анжелес дахь аль ч Санал Өгөх Төвд өөрийн биеэр ирж Болзолт сонгогчийн бүртгэлээр санал өгөх боломжтой. (тухайн-өдрийн бүртгэл).

БИ СОНГОГЧДЫН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛЭЭ ХЭЗЭЭ ШИНЭЧЛЭХ ВЭ?

- ▲ Сонгогч нүүсэн, нэрээ сольсон, эсвэл улс төрийн намын харьяаллаа өөрчлөхийг хүсвэл **LAVOTE.GOV** хаягаар бүртгэлээ шинэчлэх боломжтой. Тойрог, мужаас нүүсэн сонгогчид Бүртгэлийн Газрын (800) 201-8999, сонголт 2 дугаарт холбогдож бүртгэлээ цуцлах юм уу **LAVOTE.GOV** хаягаар орж Бүртгэлийг цуцлах маягтыг татаж авна уу.

ШУУДАНГААР САНАЛ ӨГӨХ

БИ ШУУДАНГААР ӨГӨХ САНАЛЫН ХУУДСАА ХЭЗЭЭ АВАХ ВЭ?

- ▲ Шуудангаар Өгөх Саналын хуудсыг 10-р сарын 6-наас эхлэн бүртгэлтэй бүх сонгогчдод шуудангаар илгээнэ.

БИ ШУУДАНГААР ӨГӨХ САНАЛАА ХААНА БАЙГААГ ХЭРХЭН МЭДЭХ ВЭ?

- ▲ Сонгогчид california.ballottrax.net хаягаар "**Миний саналын хуудас хаана байна**" сайтад бүртгүүлснээр саналын хуудсаа хянах боломжтой. Энэ бол таны саналын хуудасны статусын талаар мессеж, цахим шуудан эсвэл дуут шуудангаар автомат мэдэгдэл илгээдэг үнэгүй захиалга юм.

БИ САНАЛЫН ХУУДАС ХИЙХ ХАЙРЦАГНЫ БАЙРШИЛЫН ЖАГСААЛТИЙГ ХААНААС ОЛОХ ВЭ?

- ▲ Онлайнаар **LAVOTE.GOV**.
- ▲ Сонгогчийн оршин суугаа газрын ойролцоо Саналын Хуудас Хийх Хайрцагны тохиромжтой газруудын жагсаалтыг шуудангаар санал өгөх багцад оруулсан болно.

БИ ЯАГААД БУЦААХ ДУГТУЙНД ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?

- ▲ Бүртгэлийн ажилтан нь буцах дугтуйн дээрх гарын үсгийг сонгогчийн бүртгэлийн баримт дахь гарын үсэгтэй тулгаж, сонгох эрхийг баталгаажуулна.

БИ ТӨРСӨН ӨДРӨӨ ЭСВЭЛ БУЦААЖ БАЙГАА ӨДРӨӨ БУЦААХ ДУГТУЙН ДЭЭР БИЧИХ ҮҮ?

- ▲ Саналын хуудсыг буцаасан огноог оруулна. Сонгогч оронд нь төрсөн огноогоо оруулбал саналын хуудсыг боловсруулах ч, баталгаажуулсны дараа тоолох болно.

БИ ХЭЗЭЭ САНАЛЫН ХУУДСАА ӨГӨХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

- ▲ Сонгогчид саналын хуудсаа хүлээж авсан даруйдаа буцаах боломжтой.
- ▲ Бүх саналын хуудсыг шуудангаар тэмдэглэгдэж, Саналын Хуудас Хийх Хайрцаг эсвэл Санал Өгөх Төвд сонгуулийн өдөр гэхэд буцааж өгсөн байх ЁСТОЙ.
- ▲ Бүртгэлийн ажилтан нь сонгуулийн өдөр шуудангаар тэмдэглэгдсэн ба сонгуулийн өдрөөс хойш 7 хоногийн дотор хүлээн авсан саналын хуудсуудыг хүлээн зөвшөөрнө.



LOS ANGELES ТОЙРОГ БҮРТГЭГЧ-ТЭМДЭГЛЭГЧ/ТОЙРГИЙН АЖИЛТАН

2022 ОНЫ АРВАННЭГДҮГЭЭР САРЫН ЕРӨНХИЙ СОНГУУЛИЙН ТУХАЙ Б.А.А

ШУУДАНГААР САНАЛ ӨГӨХ

❓ БИ САНАЛЫН ХУУДАС ХҮЛЭЭЖ АВАХГҮЙ ЭСВЭЛ ГЭМТЭЭВЭЛ ЯАХ ВЭ?

- ▲ Сонгогчид **LAVOTE.GOV/REPLACEBALLOT**. х аягаар орж саналын хуудсыг солих хүсэлт гаргаж болно. Солих хүсэлт гаргах сүүлийн өдөр бол **Арваннэгдүгээр сарын 1**.
- ▲ (800) 815-2666, сонголт 2 руу залгаж эсвэл votebyemail@rrcc.lacounty.gov хаяг руу овог нэр, төрсөн огноо, хаягаа цахим шуудан илгээнэ үү.

❓ БИ ШУУДАНГААР ӨГӨХ САНАЛЫН ХУУДСАА ХЭРХЭН ӨӨР ХЭЛЭЭР ЗАХИАЛЖ АВАХ ВЭ?

- ▲ Саналын хуудасны ар талд байгаа Хэлний хүсэлтийн маягтыг бөглөж, буцааж илгээнэ.
- ▲ (800) 815-2666, сонголт 3, Бүртгүүлэгчийн Олон Хэлний Үйлчилгээний хэсэг рүү залгаарай.
- ▲ Дэмжигдсэн хэл: Армен, Хятад, Кхмер, Фарс, Солонгос, Испани, Тагалог, Вьетнам, Хинди, Япон, Тайланд, Орос, Бирм, Тэлугу, Гужарати, Индонези, Монгол, Бенгал.

БИЕЧЛЭН САНАЛ ӨГӨХ

❓ БИ БИЧЛЭН САНАЛ ӨГЧ БОЛОХ УУ?

- ▲ Тийм. Сонгогчид **Аравдугаар сарын 6**-ны өдрөөс эхлэн аль ч Санал Өгөх Төвд биеэчлэн саналаа өгөх боломжтой.
- ▲ Санал Өгөх Төвүүд өдөр бүр 10:00-19:00 цаг, Сонгуулийн Өдөр 07:00-20:00 цаг хүртэл нээлттэй байна.

❓ БИ СОНГУУЛИЙН ТӨВИЙГ ХЭРХЭН ОЛОХ ВЭ?

- ▲ **LOCATOR.LAVOTE.GOV** хаягаар зочилж, Санал Өгөх Төвийн апп-ыг үзэх эсвэл (800) 815-2666, сонголт 1 рүү залгана уу.
- ▲ Энэхүү апп нь LA Тойрог дахь Санал Өгөх Төвийн бүх байршил, тэдгээрийн тооцоолсон хүлээх хугацааг харуулдаг.
- ▲ Бүртгүүлсэн сонгогч бүрд 10-р сарын дундуур гэрт нь хамгийн ойр байрлах Санал Өгөх Төвийн байршлыг бичсэн жагсаалтыг тусад нь шуудангаар илгээх болно.

❓ БИ ХЭЗЭЭ БИЕЧЛЭН САНАЛАА ӨГӨХ БОЛОМЖТОЙ ВЭ?

- ▲ Сонгогчид **Аравдугаар сарын 29-нөөс** эхлэн дурын Санал Өгөх Төвд зочилж болно.
- ▲ Эрт санал өгөх боломжийг ашиглаж, саналаа эрт өгнө үү.

❓ ТА САНАЛ АВАХ ТӨВҮҮДЭЭ COVID-19-өөс ХЭРХЭН АЮУЛГҮЙ БАЙЛГАХ ВЭ?

- ▲ Бүх Санал Өгөх Төвүүд нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлын одоогийн удирдамжийг дагаж мөрддөг.
- ▲ Сонгуулийн ажилчид амны хаалт зүүж, гадаргууг тогтмол арчих болно.
- ▲ Сонгогчдыг амны хаалт зүүхийг дэмжиж байна.

❓ БИ САНАЛ ӨГӨХ ТӨВ ДЭЭР САНАЛ ӨГӨХИЙН ТУЛД ҮНЭМЛЭХ ҮЗҮҮЛЭХ ХЭРЭГТЭЙ ҮҮ?

- ▲ Калифорнийн хуулиар бүртгэлтэй сонгогчид санал өгөхдөө үнэмлэхээ харуулах шаардлагагүй.
- ▲ Хэдий тийм боловч сонгогч анх удаагаа бүртгүүлж байгаа бол тэд зурагтай иргэний үнэмлэх эсвэл Нийгмийн даатгалын дугаарын сүүлийн дөрвөн оронтой тоогоор хангах ёстой.